



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9 (390)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай*
- *Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны гуравдугаар сарын 7

№9 (390)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|------------------------------------------------------------------------------------------|-----|
| 601. | Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай | 154 |
| 602. | Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай | 154 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|------------------------------------------------------------------|-----------|-----|
| 603. | Конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай | Дугаар 21 | 154 |
|------|------------------------------------------------------------------|-----------|-----|

Гурав. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | |
|------|-----------------------------------------------------|-----|
| 604. | Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц | 154 |
| 605. | Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц | 161 |

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|--------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|
| 606. | Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 10 | 162 |
| 607. | Даваажавын Батсүхэд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 14 | 167 |
| 608. | Рүвжирийн Сандуйжавт Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай | Дугаар 15 | 168 |
| 609. | Рэнчингийн Дуламсүрэнд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 16 | 168 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 2 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ 29 ДҮГЭЭР КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 1930 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Женев хотноо баталсан Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр Конвенцид Монгол Улс нэгдэн

орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 2 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ТУХАЙ 105 ДУГААР КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 1957 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Женев хотноо баталсан Албадан хөдөлмөрийн устгах тухай 105 дугаар Конвенцид Монгол Улс

нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.13-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Конвенцид нэгдэн орсныг тус тус соёрхон баталсантай холбогдуулан зохих хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Ц. Элбэгдорж/-т даалгасугай.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 1930 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр Конвенц, 1957 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталсан Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ 29 ДҮГЭЭР КОНВЕНЦ

*1930 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлаж,
1932 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон*

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,

шийдвэрлэж,

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1930 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан арван дөрөв дэх удаагийн чуулганаараа,

эдгээр саналыг олон улсын конвенцийн хэлбэрт оруулахаар шийдвэрлэж,

чуулганы хэлэлцэх хэргийн нэг дэх асуудал болох албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн талаархи тодорхой саналуудыг батлахаар

нэг мянга есөн зуун гучин оны зургадугаар сарын хорин наймны энэ өдөр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн дагуу гишүүд соёрхон батлах доорхи конвенцийг Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенц гэж нэрлэхээр тогтож батлав:

1 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг соёрхон батласан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг аль болох богино хугацаанд арилгах үүрэг хүлээнэ.

2. Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг бүрэн арилгахтай холбогдуулан ийм хөдөлмөрийг шилжилтийн үед зөвхөн нийгмийн зорилгоор онцгой арга хэмжээ болгон энэхүү конвенцийн дараахь зүйлүүдэд дурдсан нөхцөл, баталгааг хангасан тохиолдолд хэрэглэж болно.

3. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн дараа, мөн доорхи 31 дүгээр зүйлд заасан тайланг Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс бэлтгэх үед уг Зөвлөл албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг шилжилтийн үеийг дахин сунгахгүйгээр арилгах боломжийг, түүнчлэн энэ асуудлыг Бага хурлын хэлэлцэх хэрэгт оруулах эсэхийг авч үзнэ.

2 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийн зорилгоор "албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр" гэж ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж аливаа этгээдээр гүйцэтгүүлэх, чингэхдээ уг этгээд нь өөрөө сайн дураар гүйцэтгэхийг санал болгоогүй бүх ажил буюу үйлчилгээг хэлнэ.

2. Гэхдээ энэхүү конвенцийн "албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр" гэдэг нэр томъёонд дараахь зүйлийг оруулахгүй:

(а) цэргийн алба заавал хаахыг заасан хуулийн дагуу цэвэр цэргийн шинжтэй ажил гүйцэтгэхтэй холбогдсон аливаа ажил буюу үйлчилгээ;

(б) өөрийгөө бүрэн удирдах улсын иргэний хувьд хүлээсэн иргэний ердийн үүргийн хэсэг болох аливаа ажил буюу үйлчилгээ;

(с) шүүхийн шийдвэрээр ногдуулсан шийтгэлийн үр дүнд аливаа этгээдээр гүйцэтгүүлэх ажил буюу үйлчилгээ, гэхдээ уг ажил буюу үйлчилгээг төрийн эрх бүхий байгууллагын хяналтан дор гүйцэтгэх бөгөөд тэрхүү этгээдийг хувь хүн, компани эсхүл нийгэмлэгийн мэдэлд хөлслөх буюу шилжүүлэхгүй байх ёстой;

(д) онцгой тохиолдолд, өөрөөр хэлбэл, дайн буюу гамшгийн үед эсхүл гамшиг тулгарсан үед, тухайлбал гал түймэр, үер, өлсгөлөн, газар хөдлөлт, гоц халдварт өвчний тархалт, амьтан,

шавьж буюу ургамлын хортон шавьжны нүүдэл, ер нь нийт хүн ам буюу хүн амын хэсэг амьд явах буюу хэвийн амьдрахад аюул учруулах аливаа нөхцөл байдалд гүйцэтгэх аливаа ажил, үйлчилгээ;

(е) бүлэглэлийн шууд ашиг тусын тулд тухайн бүлэглэлийн гишүүдийн гүйцэтгэдэг бөгөөд тиймээс тухайн бүлэглэлийн гишүүдийн иргэний ердийн үүрэг гэж үзэж болох хамтын шинжтэй жижиг үйлчилгээ, гэхдээ энэ үйлчилгээ хэрэгтэй эсэх талаар бүлэглэлийн гишүүд буюу тэдний шууд төлөөлөгчтэй зөвлөлдөх ёстой.

3 дугаар зүйл

Энэхүү конвенцийн зорилгоор "эрх бүхий байгууллага" гэж тухайн улсын эрх барих байгууллага буюу тухайн нутаг дэвсгэрийн эрх барих төв дээд байгууллагыг хэлнэ.

4 дүгээр зүйл

1. Эрх бүхий байгууллага нь хувь хүн, компани, нийгэмлэгийн ашгийн тулд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг гүйцэтгүүлэх буюу гүйцэтгүүлэхийг зөвшөөрөх ёсгүй.

2. Хэрэв энэхүү конвенцийг аль нэг гишүүн соёрхон батласныг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал бүртгэх үед тухайн улсад албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг хувь хүн, компани эсхүл нийгэмлэгийн ашгийн тулд хэрэглэж байгаа бол тухайн гишүүн энэхүү конвенц уг гишүүний хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тэрхүү албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг бүрэн арилгана.

5 дугаар зүйл

1. Хувь хүн, компани эсхүл нийгэмлэгт олгох аливаа концесс нь тэдгээр хувь хүн, компани эсхүл нийгэмлэгийн ашиглах буюу арилжих бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эсхүл хуримтлуулах зорилгоор албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн ямарваа хэлбэрийг хамруулж болохгүй.

2. Хэрэв албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг тийм концесст тусгасан бол тэдгээр заалтыг энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх үүднээс аль болох богино хугацаанд хүчингүй болгоно.

6 дугаар зүйл

Хэдийгээр захиргааны албан тушаалтнууд хүн амыг аливаа хэлбэрийн хөдөлмөрт татан оролцуулахыг хөхиулэн дэмжих үүрэгтэй ч тухайн

2. Ажилчныг албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлж буй эрх бүхий аливаа байгууллага нь үйлдвэрлэлийн осол буюу мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас өөрийгөө тэжээх чадвараа бүрэн буюу хэсэгчлэн алдсан ажилчны амьдрах боломжийг бүрдүүлэх, түүнчлэн тухайн ажилчин хөдөлмөр эрхэлж байх үедээ хөдөлмөрийн чадвараа алдсан буюу нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан аливаа хүнийг амьдрах нөхцлөөр хангах арга хэмжээ авах үүргийг ямар ч тохиолдолд хүлээнэ.

16 дугаар зүйл

1. Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлж буй хүмүүсийг онцгой шаардлагатай тохиолдлоос бусад үед хоол хүнс, цаг агаарын хувьд дассан нөхцлөөс нь эрс ялгаатай, улмаар эрүүл мэндэд нь аюул учруулж болох нөхцөлтэй газарт шилжүүлж болохгүй.

2. Ажилчны дасан суурьших, эрүүл мэндийг нь хамгаалахад шаардагдах эрүүл ахуй, орон сууцны нөхцлийг хангах бүх арга хэмжээг чанд хэрэгжүүлээгүй тохиолдолд ажилчдыг өөр газарт шилжүүлэхийг ямар ч тохиолдолд зөвшөөрч үл болно.

3. Хэрэв зайлшгүй ингэж шилжүүлэх бол хоол хүнс, цаг агаарын шинэ нөхцөлд ажилчдыг ажмаар дасгах арга хэмжээг эмнэлгийн зохих байгууллагатай зөвлөлдсөний дагуу авна.

4. Хэрэв ажилчин өөрт дадал болоогүй ажлыг тогтмол гүйцэтгэхээр дайчлагдсан бол тэднийг ажилд нь дасгах, ялангуяа ажмаар сургах, ажил, амралтын цаг, завсарлага, хоол хүнсийг нэмэгдүүлэх буюу сайжруулах зэрэг шаардлагатай арга хэмжээ авна.

17 дугаар зүйл

Ажилчдыг ажлын байрандаа удаан хугацаагаар байхыг шаардсан барилгын буюу засварын ажилд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрөхөөс өмнө эрх бүхий байгууллага дараахь зүйлийг тогтоосон байна:

(1) ажилчдын эрүүл мэндийг хамгаалах болон эмнэлгийн шаардлагатай үйлчилгээгээр хангах шаардлагатай бүх арга хэмжээг авсан байх, тухайлбал: (a) ажилчид ажилд орохоосоо өмнө, мөн ажиллаж байх үедээ тодорхой хугацаанд эмнэлгийн үзлэгт тогтмол хамрагдах; (b) бүх шаардлагыг хангахуйц диспансер, сувилал, эмнэлгийн багаж төхөөрөмж бүхий эмнэлэг, эмнэлгийн зохих ажилтан байгаа эсэх; (c) ажлын

байрны ариун цэврийн байдал, ундны ус, хоол, түлш, гал тогооны хэрэгсэл, мөн шаардлагатай тохиолдолд хувцас, орон сууцны хангамж хангалттай эсэх;

(2) мөн ажилчдын гэр бүлийг амьдрах боломжоор хангах, тухайлбал, ажилчин хүссэн буюу зөвшөөрсний үндсэн дээр цалингийнх нь тодорхой хэсгийг найдвартай аргаар гэр бүлд нь илгээхэд туслах;

(3) ажлын байрандаа ирэх болон буцах зардлыг захиргаанаас хариуцуулан гаргуулж, тээврийн бүх боломжтой хэрэгслийг аль болох бүрэн ашиглах замаар хөнгөвчлөх;

(4) өвчлөх буюу үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа тодорхой хугацаагаар алдсан бол тухайн ажилчныг захиргааны зардлаар гэрт нь буцаах;

(5) албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн хугацаа дууссаны дараа сайн дураар ажиллах ажилчнаар үлдэхийг хүссэн аливаа ажилчин тийнхүү үлдэхийг зөвшөөрөх бөгөөд чингэхдээ тэрээр хоёр жилийн турш гэртээ үнэ төлбөргүй харих эрхээ алдахгүй.

18 дугаар зүйл

1. Зөөгч, завьчин зэрэг ачаа буюу хүн тээвэрлэх, зөөх зорилгоор албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг аль болох богино хугацаанд арилгана. Тэр хүртэл эрх бүхий байгууллага нь *inter alia* дараахь асуудлыг зохицуулсан журам гаргана: (a) ийм хөдөлмөрийг зөвхөн захиргааны албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэх үеийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх, захиргааны хөрөнгийг тээвэрлэх эсхүл онцгой шаардлагатай зарим тохиолдолд албан тушаалтан бус хүмүүсийг тээвэрлэх зорилгоор ашиглах; (b) эмнэлгийн үзлэг хийх боломжтой бол ийнхүү хөдөлмөрлөх ажилчид нь уг ажилд бие бялдрын хувьд тэнцэх тухай эмнэлгийн магадлагаа гарсан байх, хэрэв эмнэлгийн үзлэг хийх боломжгүй бол тийм ажилчдыг ажиллуулж буй этгээд тэдгээр нь бие бялдрын хувьд тэнцэж, амьсгалын буюу ахуйн замын ямарваа халдварт өвчнөөр өвчлөөгүй гэдгийг батлах хариуцлагыг хүлээх; (c) ажилчдын зөөж болох ачааны дээд хэмжээ; (d) ажилчдыг гэрээс нь холдуулж болох хамгийн холын зай; (e) нэг сар эсхүл өөр тодорхой хугацааны турш тийнхүү хөдөлмөрлүүлж болох өдрийн тооны дээд хэмжээг гэртээ харих хугацааг оруулан тогтоох; (f) албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн ийм хэлбэрт татан оролцуулах эрх бүхий этгээд, түүний эрх хэмжээний хүрээ.

2. Дээрх хэсгийн (с), (d), (e) дэд хэсэгт заасан дээд хэмжээг тогтооходоо эрх бүхий байгууллага нь ажилчдыг хөлслөх хүн амын бие бялдрын хөгжил, ажилчдын зорчих нутгийн шинж чанар, тухайн нутгийн уур амьсгалын нөхцөл зэрэг холбогдох бүх хүчин зүйлийг авч үзнэ.

3. Үүнээс гадна эрх бүхий байгууллага дээрх ажилчдын өдөр тутмын ердийн маршрутыг ажлын найман цаг бүхий дундаж өдөртэй дүйцэх зайнаас илүүгүй байлгах бөгөөд чингэхдээ зөөх ачааны жин, туулах замын уртыг хэмжих төдийгүй замын байдал, жилийн улирал, бусад холбогдох бүх хүчин зүйлийг харгалзан үзэж, өдөр тутмын ердийн маршрутаас илүү цаг зарцуулсан тохиолдолд ажлын хөлсийг ердийн үнэлгээнээс дээгүүр тооцож олгоно.

19 дүгээр зүйл

1. Эрх бүхий байгууллага нь хөрс сийрүүлэхэд заавал хийлгэх ажлын зөвшөөрлийг зөвхөн өлсгөлөн буюу хүнсний хангамжийн дутагдлаас сэргийлэх арга хэрэгсэл болгож, мөн үүний үр дүнд авах хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь түүнийг үйлдвэрлэсэн хувь хүн буюу бүлэглэлийн өмчлөлд үлдээх нөхцлөөр олгоно.

2. Энэ зүйлийг хууль буюу зан заншлынхаа дагуу үйлдвэрлэлийг хамтын зарчмаар зохион байгуулдаг, түүнчлэн бүтээгдэхүүн, түүний борлуулалтаас олсон ашиг нь тухайн бүлэглэлийн өмчлөлд үлддэг бүлэглэлийн гишүүдийн хууль буюу зан заншлын дагуу бүлэглэлийн шаардсан ажлыг гүйцэтгэх үүргийг дуусгавар болгоно гэж ойлгохгүй.

20 дугаар зүйл

Аль нэг гишүүний үйлдсэн гэмт хэргийн төлөө бүлэглэлд нь шийтгэл ногдуулахаар заасан хууль тогтоомжид шийтгэлийн төрөл болгож бүлэглэлээр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлэх тухай заалт тусгаж болохгүй.

21 дүгээр зүйл

Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг уурхайн газар доорхи ажилд эрхлүүлж үл болно.

22 дугаар зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 22 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцийг соёрхон батласан гишүүдийн уг конвенцийг хэрэгжүүлэх талаар авч байгаа арга хэмжээний талаар жил тутам Олон улсын хөдөлмөрийн товчоонд илгээх тайланд холбогдох нутаг дэвсгэр

тус бүрийн талаар аль болох бүрэн мэдээлэхдээ тухайн нутаг дэвсгэрт албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг эрхлүүлж байгаа хүрээ, ийм хөдөлмөрийг ашиглах болсон зорилго, өвчлөл ба нас баралтын түвшин, ажлын цаг, цалин олгох журам, цалингийн үнэлгээ, бусад холбогдох аливаа мэдээллийг багтаана.

23 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг ашиглах тухай бүрэн бөгөөд тодорхой журам гаргана.

2. Тэрхүү журамд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлж буй аливаа этгээд хөдөлмөрийн нөхцлийн талаар эрх бүхий байгууллагад аливаа гомдол гаргахыг зөвшөөрч, эдгээр гомдлыг шалган магадлаж, анхааралдаа авч байхыг баталгаажуулсан дүрэм *inter alia* багтсан байна.

24 дүгээр зүйл

Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн тухай журмыг чанд хэрэгжүүлэх талаар зохих арга хэмжээг бүх тохиолдолд авах бөгөөд чингэхдээ сайн дураар эрхлэх хөдөлмөрт хяналт шалгалт хийх хөдөлмөрийн хяналт шалгалтын байгууллагын үүргийг өргөсгөн албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрт хяналт шалгалт хийдэг болгох эсхүл бусад зохистой арга хэрэглэнэ. Мөн албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлж буй хүмүүст эдгээр журмын талаар мэдээлэл өгөх арга хэмжээ авна.

25 дугаар зүйл

Хууль бусаар албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд энэхүү конвенцийг соёрхон батлаж буй гишүүн бүр хуулийн дагуу ногдуулах уг шийтгэл нь үнэхээр тохиромжтой байх, уг шийтгэлийг чанд эдлүүлэх явдлыг хангана.

26 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг соёрхон батласан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр энэхүү конвенцийг бүрэн эрхт байдал, шүүхийн харьяалал, хамгаалалт, сюзеренитет, халамж, удирдлаганд байгаа нутаг дэвсгэрт дотоодын шүүхийн харьяаллын асуудалд холбогдох үүрэг хүлээж авах эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ. Гэхдээ хэрэв тухайн гишүүн нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 35 дугаар зүйлийн заалтуудыг хэрэглэх хүсэлтэй бол энэхүү

конвенцийг соёрхон батлахдаа дараахь зүйлийг тусгасан мэдэгдэл хавсаргана:

(1) энэхүү конвенцийн заалтуудыг ямарваа өөрчлөлтгүйгээр хэрэглэх гэж буй нутаг дэвсгэр;

(2) энэхүү конвенцийн заалтуудад өөрчлөлт оруулан хэрэглэх гэж буй нутаг дэвсгэр болон уг өөрчлөлтийг нарийвчилсан заалт;

(3) өөрийн шийдвэрийг хадгалан үлдээх нутаг дэвсгэр.

2. Дээрх мэдэгдлийг соёрхон батласан батламж жуух бичгийн салшгүй хэсэг гэж үзэх бөгөөд мэдэгдэл нь соёрхон батласантай адил хүчин төгөлдөр байна. Дараа нь мэдэгдэл хийснээр аль ч гишүүн энэ зүйлийн 2, 3 дахь дэд хэсэгт заасны дагуу анхны мэдэгдэл хийсэн тайлбарыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож болно.

27 дугаар зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрэмд заасан нөхцлийн дагуу энэхүү конвенцийг соёрхон батласан тухай албан ёсны батламж жуух бичгийг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр илгээнэ.

28 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон батласан тухай батламж жуух бичгээ Олон улсын хөдөлмөрийн товчоонд бүртгүүлсэн гишүүний хувьд зөвхөн заавал биелэгдэнэ.

2. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын хоёр гишүүний соёрхон батласан тухай батламж жуух бичгийг Ерөнхий захирал бүртгэсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

3. Түүнээс хойш энэхүү конвенц аливаа гишүүний хувьд соёрхон батласан тухай батламж жуух бичгээ бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын хоёр гишүүний соёрхон батласан тухай батламж жуух бичгийг Олон улсын хөдөлмөрийн товчоонд бүртгэмэгц Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бүх гишүүнд энэ тухай мэдэгдэнэ. Тэрбээр Байгууллагын бусад гишүүн хойшид соёрхон батласан тухай батламж жуух бичгийг

бүртгэсэн тухай үүний адилаар гишүүдэд мэдэгдэнэ.

30 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг соёрхон батласан гишүүн энэхүү конвенц анх хүчин төгөлдөр болсноос хойш арван жилийн дараа Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд конвенцийг цуцлах тухай мэдэгдлээ бүртгүүлэхээр илгээж цуцлах эрхтэй. Цуцлалт нь Олон улсын хөдөлмөрийн товчоонд бүртгүүлснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенцийг соёрхон батласан гишүүн бүр дээрх хэсэгт заасан арван жилийн хугацаа дууссаны дараа нэг жилийн дотор энэ зүйлд заасны дагуу цуцлах эрхээ хэрэгжүүлээгүй бол түүний хувьд конвенц дараагийн таван жилийн хугацаанд заавал биелүүлэх хүчинтэй хэвээр байх бөгөөд түүнээс хойш таван жилийн хугацаа өнгөрөх бүрт энэ зүйлд заасан нөхцлийн дагуу энэхүү конвенцийг цуцалж болно.

31 дүгээр зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай гэж үзвэл энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухай тайланг Ерөнхий бага хуралд илтгэж, конвенцийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хянаж өөрчлөх тухай асуудлыг Бага хурлын хэлэлцэх хэрэгт оруулах эсэх талаар шалган магадлана.

32 дугаар зүйл

1. Бага хурал энэхүү конвенцийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хянаж өөрчилсөн конвенц шинээр батласан тохиолдолд аль нэг гишүүн хянаж өөрчилсөн шинэ конвенцийг соёрхон батласнаар дээрх шинэ конвенц хүчин төгөлдөр болбол буюу болоход 30 дугаар зүйлийн заалтыг үл харгалзан энэхүү конвенц хойшлуулах шаардлагагүйгээр *ipso jure* хүчингүй болно.

2. Хянаж өөрчилсөн шинэ конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш энэхүү конвенц нь гишүүд соёрхон батлахад хаалттай болно.

3. Гэхдээ энэхүү конвенцийг соёрхон батласан боловч хянаж өөрчилсөн шинэ конвенцийг соёрхон батлаагүй гишүүний хувьд энэхүү конвенц нь хэлбэр, агуулгаараа хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

33 дугаар зүйл

Энэхүү конвенцийн англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ТУХАЙ 105 ДУГААР КОНВЕНЦ

1957 оны 6 дугаар сарын 25-ны өдөр батлаж,
1959 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болсон

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1957 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан дөч дэх удаагийн чуулганаараа,

чуулганы хэлэлцэх хэргийн дөрөв дэх асуудал болох албадан хөдөлмөрийн тухай асуудлыг анхааралдаа авч,

Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенцийн заалтыг тэмдэглэн,

Боолчлолын тухай 1926 оны конвенцид заавал хийлгэх буюу албадан хөдөлмөр нь боолчлолтой төстэй хэлбэрт шилжихээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авахаар заасныг болон Боолчлолыг устгах, боолын худалдаа хийх, боолчлолтой ижил үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай 1956 оны нэмэлт конвенцээр өрийн барьцаа болгох, хамжлагат ёсыг бүрмөсөн устгасныг тэмдэглэн,

Цалингийн хамгаалалтын тухай 1949 оны конвенцид цалинж цаг хугацаанд нь олгохоор заасныг болон ажил эрхлэхээ болих бодит боломжийг хаагдуулсан хөдөлмөрийн хөлс олгох аливаа арга хэлбэрийг хориглосныг тэмдэглэн,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд дурдаж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зарлан тунхагласан хүний эрхийг зөрчиж байгаа албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн зарим төрлийг устгах тухай нэмэлт саналыг батлахаар тогтож,

эдгээр саналыг олон улсын конвенцийн хэлбэрт оруулахаар шийдвэрлэж,

нэг мянга есөн зуун тавин долоон оны зургадугаар сарын хорин тавны энэ өдөр доорхи конвенцийг Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны конвенц гэж нэрлэхээр тогтож батлав.

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийг соёрхон батласан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хориглож, дараахь зорилгоор ашиглахыг таслан зогсооно:

(а) улс төрийн нөлөөнд оруулах болон хүмүүжлийн арга хэрэгсэл болгох, эсхүл улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны эсрэг чиглэсэн улс төрийн үзэл бодол буюу оюун санааны үзэл бодолтой байх, түүнийг илэрхийлсний төлөө ногдуулах шийтгэл болгох;

(б) эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор ажиллах хүчийг дайчлах, ашиглах арга хэлбэр болгох;

(с) хөдөлмөрийн сахилга батыг сахиулах арга хэрэгсэл болгох;

(д) ажил хаялтад оролцсонд оногдуулах шийтгэл болгох;

(е) арьс өнгө, нийгмийн байдал, яс үндэс, шашин шүтлэгээр алагчилах арга хэрэгсэл болгох.

2 дугаар зүйл

Энэхүү конвенцийг соёрхон батласан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд заасан албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг нэн даруй, бүрэн устгах талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

3 дугаар зүйл

Энэхүү конвенцийг соёрхон батласан тухай албан ёсны батламж жуух бичгийг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр илгээнэ.

4 дүгээр зүйл

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон батласан тухай батламж жуух бичгээ Ерөнхий захиралд бүртгүүлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүний хувьд зөвхөн заавал биелэгдэнэ.

2. Хоёр гишүүний соёрхон батласан тухай батламж жуух бичгийг Ерөнхий захирал бүртгэсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

3. Түүнээс хойш энэхүү конвенц аливаа гишүүний хувьд соёрхон батласан тухай батламж

жуух бичгээ бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

5 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг соёрхон батласан гишүүн энэхүү конвенц анх хүчин төгөлдөр болсноос хойш арван жилийн дараа Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд конвенцийг цуцлах тухай мэдэгдлээ бүртгүүлэхээр илгээж цуцлах эрхтэй. Цуцлалт нь бүртгүүлсэнээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенцийг соёрхон батласан гишүүн бүр дээрх хэсэгт заасан арван жилийн хугацаа дууссаны дараа нэг жилийн дотор энэ зүйлд заасны дагуу цуцлах эрхээ хэрэгжүүлээгүй бол түүний хувьд конвенц дараагийн арван жилийн хугацаанд заавал биелүүлэх хүчинтэй хэвээр байх бөгөөд түүнээс хойш арван жилийн хугацаа өнгөрөх бүрт энэ зүйлд заасан нөхцлийн дагуу энэхүү конвенцийг цуцалж болно.

6 дугаар зүйл

1. Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал нь Байгууллагын гишүүн энэхүү конвенцийг соёрхон батласан болон цуцалсныг бүртгэсэн тухайгаа Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүдэд мэдээлнэ.

2. Соёрхон батласан тухай хоёр дахь батламж жуух бичгийг бүртгэсэн тухай Ерөнхий захирал Байгууллагын гишүүдэд мэдээлэхдээ энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болох хугацааг сануулна.

7 дугаар зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал энэхүү конвенцийг дээрх зүйлд зааснаар соёрхон батласан болон цуцалсан тухай

дэлгэрэнгүй мэдээллийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр илгээнэ.

8 дугаар зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай гэж үзвэл, энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухай тайланг Ерөнхий бага хуралд илтгэж, конвенцийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хянаж өөрчлөх тухай асуудлыг Бага хурлын хэлэлцэх хэрэгт оруулах эсэх талаар шалган магадлана.

9 дүгээр зүйл

1. Бага хурал энэхүү конвенцийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хянаж өөрчилсөн конвенц шинээр батласан тохиолдолд, тухайн конвенцид өөрөөр заагаагүй бол:

(а) аль нэг гишүүн хянаж өөрчилсөн конвенцийг соёрхон батласнаар шинэ конвенц хүчин төгөлдөр болбол эсхүл болох үед 5 дугаар зүйлийн заалтыг үл харгалзан энэхүү конвенц *ipso jure* хүчингүй болно;

(б) хянаж өөрчилсөн шинэ конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш энэхүү конвенц нь гишүүд соёрхон батлахад хаалттай болно.

2. Энэхүү конвенцийг соёрхон батласан боловч хянаж өөрчилсөн шинэ конвенцийг соёрхон батлаагүй гишүүний хувьд энэхүү конвенц нь хэлбэр, агуулгаараа аль ч тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

10 дугаар зүйл

Энэхүү конвенцийн англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, эрчим хүч, ус цаг уур, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ болон төр захиргааны

байгууллагад олон жил үр бүтээлтэй, идэвх санаачилгатай ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнаасугай

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | |
|-------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|
| 1. Сүхбаатарын Баярсайхан-Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Сулинхайрхан" ХХК-ийн ерөнхий тогоч | 2. Санжийн Дамдинсүрэн - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн секторын эрхлэгч |
|-------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|

АЛТАН ГАДАС ОДОНГООР:

- | | |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Жүрмэдийн Адъяа- Нийслэлийн Багануур дүүргийн "Боловсрол" цогцолбор сургуулийн монгол хэл-уран зохиолын багш | 12. БалааганыБаттулга- Ховд аймгийн Мөст сумын "Цаст-Алтай" цогцолбор сургуулийн орос хэлний багш |
| 2. Цэрэнхүүгийн Алтангэрэл - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-2" ХК-ийн цахилгааны засварын инженер | 13. Янсанжавын Батцоож-Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын ахлах байцаагч |
| 3.Лувсанчойдорын Алтанцэцэг- Нийслэлийн Хөгжим бүжгийн коллежийн хийл хөгжмийн багш | 14. Муухайн Билгээ-Нийслэлийн нийгэм ахуйн барилга, угсралтын "Байгууламж" ХК-ийн захирал |
| 4. Гэндэндоржийн Андил-Рашаан судлалын үндэсний төвийн тасгийн эрхлэгч | 15. Надмидын Бүтэдваань -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолборын 2 дугаар сургуулийн биологийн багш |
| 5. Товуусүрэнгийн Бадамдорж-Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Тунгалаг-Эрдэнэ" ХХК-ийн захирал | 16. Бөөхүүгийн Винтов-Орхон аймгийн Гаалийн хорооны дарга |
| 6. Чоймлогийн Бат- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хот байгуулалт, стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга | 17. Балсангийн Ганболд-Нийслэлийн Татварын газрын татвар хураалтын хэлтсийн дарга |
| 7. Дааданхүүгийн Батбаатар-Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга | 18. Аюушийн Гонгор-Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ахлах сургуулийн монгол хэл-уран зохиолын багш |
| 8. Ёлхорсүрэнгийн Батбаяр- Нийслэлийн Хөгжим бүжгийн коллежийн морин хуур хөгжмийн багш | 19. Дамдины Дагвадорж-Ус цаг уур, орчны шинжилгээний газрын хэлтсийн дарга |
| 9. Чойжилжавын Батням- Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 47 дугаар сургуулийн түүх, газарзүйн багш | 20. Лхагвын Дамба-Булган аймгийн дулаан, ус хангамж, нийтийн аж ахуйн "Булган мээж" ХХК-ийн хүний нөөцийн менежер |
| 10. Ёндонжамцын Бат-Өлзий- Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын гоцлол хөгжимчин | 21. Дамбын Дамдинсүрэн-МУБИС-ийн Биеийн тамирын сургуулийн хөнгөн атлетикийн тэнхмийн багш |
| 11. Доржийн Батсүх- МУБИС-ийн Багшийн сургуулийн багш | |



22. Жамъяншаравын Дашзэгвэ - Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч

23. Алтангэрэлийн Дашнамжил - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хорооны иргэн, ендөр настан

24. Дунийн Дашпүрэв - Нийслэлийн Барилгын коллежийн мэргэжлийн тэнхмийн эрхлэгч

25. Ширэнгийн Дуламсүрэн - Нийслэлийн Хөгжим бүжгийн коллежийн виолончель хөгжмийн багш

26. Намсрайжавын Дүгэрсүрэн - Нийслэлийн тээвэр зуучийн "Туушин" ХХК-ийн тээвэр, үйлчилгээний цогцолборын захирал

27. Амбаагийн Жанчив - Дархан-Уул аймгийн барилгын материал үйлдвэрлэлийн "Түшиг-Уул" ХК-ийн эксковаторчин

28. Гөлгөөгийн Золбоо - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

29. Нямын Лхагвасүрэн - Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын жүжигчин

30. Бирваагийн Мөнхбаяр - Улсын Филармонийн "Баян Монгол" джаз найрал хөгжмийн хөгжимчин

31. Стермөнхийн Мягмар - Нийслэлийн Багануур дүүргийн "Боловсрол" цогцолбор сургуулийн сургалт, хүмүүжлийн менежер

32. Цэдэнжавын Мягмарсүрэн - У л с ы н шүүх эмнэлгийн магадлах төвийн шүүхийн химийн шинжээч

33. Тогтохын Наранцэцэг - ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

34. Баарангийн Нямцэрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн сургууль-цэцэрлэгийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн монгол хэлний багш

35. Даваасамбуугийн Пүрэвжав - Нийслэлийн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ХК-ийн турбины машинч

36. Өвгөнхүүгийн Сарангэрэл - Дархан-Уул аймгийн Анагаах ухааны коллежийн багш

37. Сандагийн Содномцэрэн - Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

38. Өлзийхутагийн Таян - Улсын Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлгийн эмийн бус эмчилгээний тасгийн их эмч

39. Жамъянгийн Төмөр - Хэнтий аймгийн Өлзийт тосгоны цэцэрлэгийн эрхлэгч

40. Давагын Төмөр-Аюуш - Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Хүнс комплекс" ХХК-ийн ерөнхий захирал

41. Батчулууны Төмөрбаатар - Улсын Клиникийн төв эмнэлгийн мэс заслын тасгийн их эмч

42. Батбаярын Төмөрхуяг - Нийслэлийн газрын албаны дарга

43. Дашдоржийн Тунгалаг - Нийслэлийн Хөгжим бүжгийн коллежийн төгөлдөр хуур хөгжмийн багш

44. Дэндэвийн Хандсүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 20 дугаар сургуулийн монгол хэл-уран зохиолын багш

45. Доржийн Хөхөө - МУБИС-ийн Дүрслэх урлаг, технологийн сургуулийн хөдөлмөрийн багш

46. Бат-Очирын Цолмончимэг-Улсын
Клиникийн төв эмнэлгийн зүрх судасны их эмч

47. Пуувайн Цэен-Ойдов-Нийслэлийн
Баянзүрх дүүргийн 10 жилийн 14 дүгээр сургуулийн
монгол хэл-уран зохиолын багш

48. Дашийн Цэнд-Рашаан судлалын
үндэсний төвийн үзлэгчийнх эмч

49. Дашгэндэнгийн Цэнджав-ШУА-ийн
Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний
ажилтан

50. Панзын Цэрэндондов-МУБИС-ийн
сэтгэл судлалын тэнхмийн багш

51. Равжаагийн Цэрэндулам-Нийслэлийн
"Улаанбаатар зочид буудал" ХК-ийн тогооч

52. Пунцагийн Цэрэннадмид-Нийслэлийн
"Дулааны цахилгаан станц-2" ХК-ийн гүйцэтгэх
захирал

53. Жадамбын Цэцэгээ-ЭМШУИС-ийн мэс
заслын 2 дугаар тэнхмийн багш

54. Жадамбын Чулуунбат-Улсын Клиникийн
нэгдсэн 2 дугаар эмнэлгийн хүүхдийн тасгийн
сувилагч

55. Лодонгийн Шаравдорж- УБТЗ-ын
дохиолол холбооны 1 дүгээр ангийн дарга

56. Магсаржавын Янжинжав-Нийслэлийн
Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор 2
дугаар бага сургуулийн бага ангийн багш

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНГООР:

1. Пүрэвдоржийн Батбаатар-Нийслэлийн
Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх
Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн
дарга, цагдаагийн ахмад

2. Лхамжавын Ганболд-Нийслэлийн
Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх
Цагдаагийн хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгийн
дарга, хошууч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Долгорын Баатарсүрэн-Улсын
Филармонийн "Баян Монгол" джаз найрал хөгжмийн
хөгжимчин

2. Дамчаагийн Батноров- У Б Т З - ы н
дохиолол холбооны 1 дүгээр ангийн ахлах инженер

3. Дамдинпүрэвийн Баяржаргал-Сэлэнгэ
аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн
эрхлэгч

4. Цэндхүүгийн Бямбаа-Дархан-Уул
аймгийн барилгын материал үйлдвэрлэлийн "Түшиг-
Уул" ХК-ийн жолооч

5. Хаянхярваагийн Ванчигмаа-Нийслэлийн
Зам тээврийн газрын хэлтсийн дарга

6. Даваагийн Ганболд-Нийслэлийн Засаг
даргын Тамгын газрын санхүү эдийн засаг, төрийн
сангийн хэлтсийн дарга

7. Лхамсүрэнгийн Гэндэнжав- ХААИС-ийн
харъяа Дархан-Уул аймаг дахь Ургамал газар
тариалан, сургалт, эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн багш

8. Гомбын Дарьсүрэн- Улсын Клиникийн төв
эмнэлгийн амбулаторийн нүдний тасгийн сувилагч

9. Ичинхорлоогийн Дашзэвэг- Нийслэлийн
Баянзүрх дүүргийн 10 жилийн 84 дүгээр сургуулийн
бага ангийн багш

10. Дамдины Долгор- Нийслэлийн "Дулааны
цахилгаан станц-2" ХК-ийн ашиглалтын инженер

11. Дамдинсамбуугийн Должин-Нийслэлийн Баянзүрх дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвийн багш
12. Раднаагийн Зоригт -Монголын Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн захирал
13. Дүгэржавын Лундиа-Улсын Клиникийн төв эмнэлгийн эмчилгээ, чанарын хяналтын менежер
14. Сэнгийн Лхагваа- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Сувиллын цэцэрлэг-яслийн 10 дугаар цогцолборын ажилчин
15. Доржийн Лхагвасүрэн -Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Орос судлалын тэнхмийн багш
16. Төмөрийн Лянхуацэцэг- Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Талх чихэр" ХК-ийн микробиологич
17. Цэцэгээгийн Мөнхболд - Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын хийл хөгжимчин
18. Авдилын Мурат- Нийслэлийн Барилгын коллежийн материалын инженер багш
19. Пүрэвдоржийн Нарантуяа- Нийслэлийн Техник, технологийн коллежийн дэд захирал
20. Ойдовын Насанжаргал-Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалын музейн эрдэм шинжилгээний ажилтан
21. Гонсын Нацагдорж-Дархан-Уул аймгийн барилгын материал үйлдвэрлэлийн "Түшиг-Уул" ХК-ийн инженер
22. Лувсанжамбаагийн Нямсүрэн -Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Засаг даргын орлогч, Хөтөл хотын менежер
23. Ухнаагийн Нямсүрэн- "Бизнес таймс" сонин сурвалжлагч орчуулагч
24. Цэвээндоржийн Нямцэрэн- Нийслэлийн Багануур дүүргийн "Боловсрол" цогцолбор сургуулийн сургалт, хүмүүжлийн менежер
25. Батхуягийн Одхүү- Ховд аймгийн Зэрэг сумын Хөндлөн багийн Засаг дарга
26. Гончигдоржийн Орхонсайхан- Нийслэлийн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ХК-ийн эзлэгийн засварчин
27. Дэлгэрмаагийн Осгон- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 14 дүгээр сургуулийн орос хэлний багш
28. Цэдэнгийн Оюунцэцэг- Нийслэлийн "Улаанбаатар зочид буудал" ХК-ийн рестораны тогооч
29. Доржийн Оюунчимэг-Нийслэлийн Барилгын коллежийн Орос хэлний багш
30. Лувсандоржийн Пүрэвсүрэн - Ховд аймгийн геологи шинжилгээний "Алтай нэгдэл" ХК-ийн өрмийн мастер
31. ДамдиныРэгзэдмаа- П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн халдвар, хамгаалал, хяналтын албаны дарга
32. Жамцын Сүнжидмаа-Рашаан судлалын үндэсний төвийн үзлэгийн их эмч
33. Чоймболын Тогтохсүрэн- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 56 дугаар цэцэрлэгийн багш
34. Ганжуурын Тоня - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэгийн багш
35. Пүрэвдоржийн Төмөр- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн сургалтын менежер
36. Түмэндэмбэрэлийн Түвшинжаргал - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэгийн багш

37. Дашийн Уранчимэг- Нийслэлийн Барилгын коллежийн орос, англи хэлний багш

38. Мижиддоржийн Үржин- Нийслэлийн Баянгол дүүргийн Төхижилт компанийн гэрээ эрхийн байцаагч

39. Данзангийн Цогт- Нийслэлийн Барилгын коллежийн цахилгааны багш

40. Раднаагийн Цэвэлмаа- П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн зүрхний эмгэг судлалын тасгийн эрхлэгч

41. ЧимэдийнЦэрэндорж- Нийслэлийн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ХК-ийн турбин цехийн засварчин

42. Баянжиргалын Цэрэнхүү-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 10 жилийн 50 дугаар сургуулийн бага ангийн багш

43. Бүрэнгийн Цэцэгбал- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 122 дугаар цэцэрлэгийн багш

44. Нямаагийн Чимэг- ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

45. Гармаагийн Шархүү- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвийн математикийн багш

46. Сэнгээгийн Энхбаатар-Нийслэлийн "Дулааны цахилгаан станц -2" ХК-ийн зуухны засварын гагнуурчин

47. Цэдэндоржийн Энхтуяа - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Орос судлалын тэнхмийн багш

48.Базарсүрэнгийн Эрдэнэчимэг- Нийслэлийн Хөгжим бүжгийн коллежийн биеийн тамирын багш

49. Любагийн Эрдэнэчулуун-Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 14 дүгээр сургуулийн захирал

50. Бямбажавын Ягаан- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 84 дүгээр сургуулийн бага ангийн багш

51.Доржнамжилын Янжинлхам- Нийслэлийн Багануур дүүргийн Боловсролын хэлтсийн гадаад хэлний арга зүйч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР :

1. Адъяагийн Дугардорж- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Гэмшгаас хамгаалах штабын дарга, дэд хурандаа

2. Даваажавын Жавхлантмөрөн - Нийслэлийн Гал унтраах 11 дүгээр ангийн салааны захирагч, хошууч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 2 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Даваажавын Батсүхэд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Хөдөө орон нутгийн боловсролын байгууллагад багш, удирдах ажилтнаар олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж аймгийн сургуулиудын хүний нөөц, сургалтын орчныг сайжруулах, багш нарын заах арга ур чадварыг дээшлүүлэх сургалтын чанарыг ахиулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баянхонгор аймгийн Боловсрол, соёлын газрын дарга Даваажавын

Батсүхэд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н. БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 2 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Рүвжирийн Сандуйжавт Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж элэгний хорт хавдар өвчний оношилгоо, эмчилгээний шинэ аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлж, эмчилгээний үр дүнг сайжруулан хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш, Хавдар судлалын төвийн зөвлөх эмч Рүвжирийн

Сандуйжавт Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 2 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Рэнчингийн Дуламсүрэнд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээх тухай

Хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан хамт олноо чадварлаг удирдан зохион байгуулж, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулж, эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг хөдөөгийн хүн амд ойртуулан эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн захирал Рэнчингийн

Дуламсүрэнд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2